1. Чулуун зэвсгийн судалгаагаар Монгол нутагт хэдий үеэс хүн амьдарч эхэлсэн гэж үздэг вэ?
   A. 1 сая жилийн өмнөөс B. 800 мянган жилийн өмнөөс (1оноо)
   C. 40 мянган жилийн өмнөөс D. 500 мянган жилийн өмнөөс
   E. 80 мянган жилийн өмнөөс

2. Төв Азийн нүүдэлчдийн анхны төрт улс Хүннү хэдэн онд байгуулагдсан бэ?(1оноо)
   A. МЭӨ198 онB. МЭӨ 209 онC. 48 он D.93 онE. 189 он

3. Дорнод аймгийн Тамсагбулагийн суурин аль үед холбогдох вэ?(1оноо)
   A. Хуучин чулуун зэвсгийн үеB. Шинэ чулуун зэвсгийн үеC.Дунд чулуун зэвсгийн үе
   D. Хүрэл зэвсгийн үеE. Хүннүгийн үе

4. 402 ондхаан суусан, Жужан улсын хаан хэн бэ?(1оноо)
   A. ЧаругуйB. Шэлүнь C. ХэляньD. Анахуань E. Буман

5. “Миний дээд өвөг Буман мэргэн хаан бөлгөө, Баатар хаан бөлгөө” гэж тэмдэглэсэн дурсгал аль нь вэ ?(1оноо)
   A. Культегиний хөшөө B. Долоодойн булш C. Харбухын балгас
   D. Чигисийн чулууны бичигE. Аль нь ч биш

6. Европчууд, Хүннү нараас өвлөн авсан зүйл аль нь вэ? (1оноо)
   A. ДөрөөB.Тахир сэлэм C.Дуут сум D.Ясан нум E.Бүгд зөв

7. Хүннү улсын түүхэнд холбогдох хот аль нь вэ?(1оноо)
   A. Хархорум хот B. Чинтолгойн балгас C. Хөх хот
   D. Ордубалик хот E. Гуа дов, Лүн хот( Лүнтэн)

8. XI-XII зууны үед Хамаг монголын ханлиг хаагуур нутаглаж байсан бэ?(1оноо)
   A. Хэрлэн мөрөн B. Хэрлэн, Онон, Туулын сав
C.Орхон, Сэлэнгэ, Онон голын сав D. Халх голын ойролцоо
E.Орхон голын ойролцоо

9. “Чингис хааны язгуур дээд тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно гэргий Гуа маралын хамт тэнгис далай гаталж ирээд, Онон мөрний эх Бурхан халдун ууланд нутаглав” хэмээн ямар сурвалжид тэмдэглэсэн байдаг вэ? (1оноо)
   A. Алангоогийн домогтB. Эргүнэ гүнгийн домогтC.Монголын нууц товчоонд
D. Хөх судартE.Аль нь ч биш

10. Жадаран овгийн Жамуха сэцэн хэдэн онд Гүр хан хэмээн өргөмжлөгдсөн бэ?(1оноо)
A. 1189 он B.1201 онC.1204 онD.1191 онE.1202 он

11. Хиад -Боржигон овгийн онгон сүлд аль нь вэ?(1оноо)
A.Цагаан шонхорB. Нар, сарC. Начин шонхорD.Цагаан туг E.Буга

12. Эргүнэ гүнгийн домгийн гол агуулга юу вэ? (1оноо)
   A. Алангоо эх хөвүүдээ эв нэгдлийн тухай сургасан сургаал
   B. Ах дүү нар муудалцан салж нүүсэн тухай
   C. Түрэгийн үед монголчууд удам угсаагаа алдаагүй болохыг өгүүлдэг
   D. Дээрх хариулт бүгд зөв
   E. Дээрх хариулт бүгд буруу

13. Чингис хааны эцэг Есүхэй баатар ямар овгийн хүн бэ?(1оноо)
A.Хиад- боржигонB.ЖадаранC.ТайчуудD.ЖүрхинE.Баатууд

14. “Монгол” гэдэг нэрийн үүсэл гарлын талаар олон янзын үзэл, таамаглал байдаг. Эдгээрээс аль нь **хамааралгүй** вэ? (1оноо)
A.Газар усны нэртэй холбоотойB.Мон овгоос үүсэлтэйC.Алтан улс гэсэн үг
D.А ба В хариулт зөвE.Аль нь ч биш

15. Монголын нууц товчоонд “Цээлийн ус ширгэв, Цэгээн чулуу хагарав” хэмээн өгүүлсний гол утга санаа юу вэ? (1оноо)
A.Газар хөдлөлт болсонB.Ган гачиг тохиолдсон
C.Төвлөрсөн захиргаа алдагдаж, тарж бутарсан D.Дайн байлдаан болсон
E.Өвчин тахал гарсан

16. Их Монгол улсын түмний ноёдыг зөв тохируулна уу.(3оноо)
1. Төвийн түмэн а. Мухулай
2. Зүүн түмэн б. Наяа
3. Баруун түмэн в. Боорчи

A. 1а,2б,3в B.1б,2а,3в C. 1в,2а,3б D.1б,2в,3а E.1в,2б,3а

17. Чингис хааныг хоёр дахь мянганы алдарт хүнээр тодруулсан “Вашингтон пост” сонины үндэслэл юу байсан бэ? ( 2оноо)
A. Дэлхийн хэмжээний эзэнт гүрнийг байгуулсан
B. Өрнө, дорны соёл иргэншлийн хэлхээ холбоог бэхжүүлэн өнөөгийн глобальчлалын эх үүдийг нээсэн
C. Америк тивийг нээж Европ-Америкийг холбосон
D. А ба В хариулт зөв
E. В ба С хариулт зөв

18. Аль нь Чингис хааны 4 хөвгүүнийг насаар нь зөв эрэмбэлсэн байна вэ? ( 2оноо)
A.Зүчи, Өгэдэй, Цагадай, ТулуйB.Зүчи, Цагадай, Тулуй, Өгэдэй
C.Цагадай, Өгэдэй, Зүчи, Тулуй D.Өгэдэй, Зүчи, Цагадай, Тулуй
E.Зүчи, Цагадай, Өгэдэй, Тулуй

19. Өгэдэй хааны үед ямар шинэчлэл хийгдсэн бэ?(2оноо)
A. Алба татварын тогтолцоог боловсронгуй болгосон
B. Уургын улааг халж, улсын өртөөг байгуулсан
C. Аравтын дотроос дураар гаргах, орохыг хатуу хориглосон
D. Говьд худаг гаргуулж, бэлчээрийг өргөтгөсөн
E. Дээрх бүгд хамаарна

20. Дор дурдсан өгөгдлүүдээс Хубилай хаан, Эзэнт гүрний нийслэлийг хаана шилжүүлснийг олно уу?
A.Хархорумаас Хөх хотодB.Ханбалиг буюу Дайду-д(1оноо)
C.Инчан хотодD.Нанжин хотодE.Аль нь ч биш

21. Цагадайн хаант улсын түүхэнд холбогдох өгөгдлийг нэрлэнэ үү.(2оноо)
A.Дундад Азид оршиж байсан улсB.Торгоны замын гол зангилаа дайран өнгөрдөг
C. Доголон Төмөр хаан D.Самарканд
E.Бүгд хариулт зөв

22. Доорх зураг юуны тухай өгүүлж байна вэ?(1оноо)
   A. Соёмбо үсгийн дурсгал
   B. Дөрвөлжин үсгийн пайз
   C. Гүюг хааны тамганы дардас
   D. Ил хааны захидал
   E. Чингисийн чулууны бичиг



23. Түмэн хааныг яагаад "Засагт хаан" гэж нэрлэх болсон бэ?(2оноо)
   A. Баруун, зүүн, түмний ноёд язгууртны төлөөлөгчдөөс бүрдсэн Төв засгийн газар байгуулсан
   B. Баруун түмний эсэргүүцлийг дарах үүднээс засгийн газрын цэрэг байгуулсан
   C. Зүүн түмний эсэргүүцлийг дарах үүднээс засгийн газрын цэрэг байгуулсан
   D. Дээрх хариулт бүгд зөв
   E. Дээрх хариулт бүгд буруу

24. Батмөнх Даян хааны үеийг Монголын түүхийн сурвалжуудад хэрхэн томьёолсон байдаг вэ? (2оноо)
   A. Улсын нэгдмэл байдал хангагдсан
   B. Салан тусгаарласан үе
   C. "гар газар, хөл хөсөр" байсан үе
   D. "Үлэмж жаргалангаар хүн амьтныг хангаж байсан" үе
   E. Дээрх хариулт бүгд зөв

25. Халхын баруун, зүүн гарын ноёдыг эвлэрүүлэх чуулган хэзээ, хаана болсон бэ?(1оноо)
A.1640 он, Тарвагатайн Улаан бурааB.1686 он, Хүрэн бэлчир
C.1688 он, Ар Элстэй D.1691 он, Долоон нуур
E.1639 он, Ширээ цагаан нуур

26. 1755-1758 оны Манжийг эсэргүүцсэн монголын ард түмний тэмцлийн гол үр дүн юу вэ?(2оноо)
   A. Манжийн ноёрхлыг түлхэн унагасан
   B. Бие даасан Монгол улсыг байгуулсан
   C. Нийт монгол манжид эзлэгдэх аюулыг зогсоосон
   D. Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцлийг тодорхой туршлага, сургамжаар баяжуулсан
   E. Дээрх хариулт бүгд зөв

27. Халх Монгол Манжийн захиргаанд орсон оныг олно уу?(1оноо)
A.1634 онB.1637 онC.1636 онD.1691 он E.Аль нь ч биш

28. Манжийн эрхшээлийн үеийн хутагт, хувилгаадын мэдлийн хүмүүсийг ....... гэж нэрлэж байв.(2 оноо)
A.Сум ардB.Хамжлага ард C.Шавь ардD.Хишигтэн E.Хэвтүүл

29. Халх Монголд, манжийг эсэргүүцсэн 1755-1758 оны тэмцэлд ямар хэлбэр зонхилж байсан бэ?
A.Зэвсэгт бослогоB.Дугуйлангийн хөдөлгөөнC. Заргын тэмцэл (1оноо)
D. Өртөө, харуулыг хаяж босохE. Аль нь ч биш

30. Халхын шашны тэргүүнээр Занабазарыг өргөмжилсөн, 1639 он хэддүгээр зууны, хэддүгээр хагас вэ?
A.XV зууны II хагас B.XVII зууны I хагас C.XVII зууны II хагас(2оноо)
D.XVI зууны I хагас E.XVI зууны II хагас

31. Манжийн үеийн Түшээт хан аймаг нь одоогийн аль аймгуудын нутаг дэвсгэртэй дүйж байна вэ?
A.Завхан, Говь-Алтай зэрэг аймаг B.Хэнтий, Сүхбаатар зэрэг аймаг (2оноо)
C.Өвөрхангай, Төв зэрэг аймаг D.Архангай, Булган зэрэг аймаг
E.Аль нь ч биш

32. Халхын дөрвөн аймгийн аль нь хамгийн сүүлд байгуулагдсан бэ?(1оноо)
A.Түшээт хан B.Засагт хан C.Сайн ноён хан
D.Сэцэн хан E.Аль нь ч биш

33. Манжийн эрхшээлийн үед гэрээрээ очиж хаадаг албыг ..................... гэж нэрлэдэг байв.(2оноо)
A.Суман харуул B.Гэр харуул C.Алтны харуул
D.Дотуур харуул E.Цагдаа харуул

34. 1900 онд Манжийг эсэргүүцсэн монгол цэргийн бослого хаана гарсан бэ?(1оноо)
A.Улиастай B.Ховд C.Их хүрээD.Хиагт E.Аль нь ч биш

35. 1911.12.29-нд Монголчууд төрийн тусгаар тогтнолоо сэргээн Богдыг хаан ширээнд залж таван яам байгуулжээ. Гадаад яамны сайдаар хэнийг томилсон бэ?(1оноо)
A.Да лам ЦэрэнчимэдB.Намсрай ван C.Бэйс Гомбосүрэн
D.Чин ван Ханддорж E.Чагдаржав

36. Доорх зураг ямар утгатай баримт вэ?(2оноо)
A. Өрийн данс
B. Заргын бичиг
C. Цэргийн бүртгэл
D. Ургийн бичиг
E. Нугалбар бичиг



37. VIII Богдыг хаан ширээнд залж, улсын нэр, оны цолыг хэрхэн нэрлэсэн бэ? (2оноо)
A. Монгол улсын шашин төрийг хослон баригч, Нарангэрэлт түмэн наст Богд хаан
B. Шашин төрийг хослон баригч, Нарангэрэлт түмэн наст Богд хаан
C. Олноо Өргөгдсөн, Монгол улс
D. Монгол улсын шашин төрийг хослон баригч Богд хаан
E. Аль нь ч биш

38. 1912 онд Хаант Орос, Монголын хооронд байгуулагдсан " Гэрээ бичиг"-ийн гол агуулга юу вэ?
A. Монгол улсын тусгаар тогтнолыг Орос улс бүрэн хүлээн зөвшөөрсөн(2оноо)
B. Өвөр Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн
C. Хэлэлцээр амжилтгүй болж гэрээнд онц ач холбогдол бүхий зүйл тусгаж чадаагүй
D. Монгол улсыг өөртөө эзэрхэх эрхтэйгээр тогтноход Орос улс тусална гэсэн
E. Аль нь ч биш

39. Өгөгдсөн мэдээллээсБогд хаант Монгол улсын үеийн анхны иргэний сургууль хэдийд, хаана байгуулагдсныг олно уу. (1оноо)
A.1915 онд Ховдод B.1912 онд Нийслэл хүрээнд C.1912 онд Улиастайд
D.1913 онд ХүрээндE.Аль нь ч биш

40. Дундад Иргэн улсын төлөөний сайд Чен-И, Бээжингийн зааврaар Гадаад Монголын автономийг устгах ямар баримт бичиг боловсруулж ирсэн бэ?(2оноо)
A. Гурван улсын гэрээ бичиг
B. Гадаад Монголын хойчийг сайжруулах 64 зүйлийн гэрээ бичиг

C. Монголын хойчийг сайжруулах 8 зүйлийн гэрээ бичиг
D. Монголын ирээдүй цагийн бичиг
E. Автономийг устгахыг гуйсугай хэмээх бичиг

41. 1920.06.25-нд хувьсгалт хоёр бүлгийн хамтарсан хурлаас ямар шийдвэр гаргасан бэ?(2оноо)
A. “Монгол Ардын нам” хэмээх байгууллагыг үүсгэн байгуулсан
B. “Намын хүмүүсийн дагаж явах Тангарагийн бичиг”-ийг баталсан
C. Зөвлөлт Орос улсаас тусламж хүсэх төлөөлөгчдийг томилсон
D. Тодорхой шийдвэр гаргаагүй
E. D хариултаас бусад нь зөв

42. 1921 оны хувьсгалыг “Үндэсний Ардчилсан” хэмээн тодорхойлдгийн учир юу вэ?(2 оноо)
A. Хятад, цагаантны эрхшээлээс гарч, үндэсний тусгаар тогтнолоо олсон учир
B. Нийгэм, улс төрийн амьдралд ардчилсан өөрчлөлтүүдийг хийсэн тул
C. Зөвхөн Үндэсний тусгаар тогтнолоо олсон учир
D. А ба В хариулт зөв
E. Дээрх хариу бүгд буруу

43. Ардын засгийн газрын анхны бага сургууль хэдэн онд, хаана байгуулагдсан бэ?(1оноо)
A.1921 онд, Нийслэл хүрээнд B.1922 онд, Улиастайд C.1925 онд, Улаанбаатарт
D.1924 онд, Хиагтад E.1926 онд, Нийслэл хүрээнд

44. Ардын засгийн газрын Сангийн яамны анхны сайд хэн байсан бэ?(1оноо)
A. Пунцагдорж B.Д.Сүхбаатар C. Д.БодооD.Н. МагсаржавE.С.Данзан

45. Шинжлэх ухааны байгуулгын үндэс”Судар бичгийн хүрээлэн” –ийн үүрэгюу вэ?(1оноо)
A.Хууль гаргахB.Түүхэн дурсгалыг цуглуулах, хадгалах, судлах
C.Эдийн засгийн бодлого боловсруулах D. А ба В хариулт зөв E. Аль нь ч биш

46. Дор өгүүлсэн улс төрийн зүтгэлтнүүдээс хэн нь “Хэмжээт эрхт хаант засаг бол хуучнаас шинэ байгуулалд шилжих үед зайлшгүй байх ёстой засаглалын хэлбэр” гэж үзэж байсан бэ?(2оноо)
A.Д.Бодоо B. С.Данзан C. Д.СүхбаатарD.Х.ЧойбалсанE.Д.Догсом

47. Монголын эрх баригчдын дотор үндэсний ардчилсан хөгжлийн чиг шугамыг баримталж байсан, хожим “баруунтан” хэмээн нэрлэгдэх болсон хүмүүсийг нэрлэнэ үү.(2оноо)
A. Ө.Бадрах, Ц.Жигжиджав, З.Шижээ, Л.Лааган
B. А.Амар, Ж.Цэвээн, Ц.Дамбадорж, Н.Жадамба нар
C. Ө.Бадрах, Ц.Жигжиджав, Б.Цэрэндорж, А.Амар
D. А ба В хариулт зөв
E. В ба С хариулт зөв

48. Манай улсад “Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх” өдөр жил бүрийн ................-нд болдог.(2оноо)
A.9 сарын 10B.6 сарын 25C.11 сарын 26D.1 сарын 13E.5 сарын 1

49. Улаанбаатар-Наушкийн төмөр зам ашиглалтанд орсон нь ямар ач холбогдолтой вэ? (2оноо)
A.Орчин цагийн төмөр замын тээврийн салбарын үндэс тавигдсан
B.Морин өртөөг бий болгосон.
C.Төмөр замын салбарын инженер техникийн ажилчид бий болсон
D.А ба С хариулт зөв
E.Дээрх хариулт бүгд буруу

50. “Монголын ардчилсан холбоо”хэзээ, хаана байгуулагдсан бэ?(1оноо)

A.1989.12.10. УлаанбаатарB.1989.12.12. Ховд C.1990.12.10 Хөвсгөл
D.1990.12.12. ДарханE.1989.12.20Улаанбаатар

51. 2000 онд ерөнхий сайдаар ажиллаж байсан улс төрийн зүтгэлтэн хэн бэ?(1оноо)
A.Н.Багабанди B.П.ОчирбатC.Н.ЭнхбаярD.С.Зориг E.Ц.Элбэгдорж

52. Монгол улсын “Үндсэн хууль”-нд зааснаар төрийн эрх барих дээд байгууллага аль нь вэ?(1оноо)
A. УИХ B. Ерөнхийлөгч C. Засгийн газарD. Ерөнхий сайд E. Аль нь ч биш

53. Дор дурьдсан өгөгдлөөс “Учиртай гурван толгой” дуурийн зохиогчийг нэрлэнэ үү.(1оноо)
A. Л.Ванган B. Э.Оюун C. Д.НамдагD. Ч.ОйдовE. Б.Дамдинсүрэн

54. XX зууны Монголын .................... үнэтэй хувь нэмэр оруулсан төлөөлөгчид бол С.Эрдэнэ, Д.Намдаг, Б.Догмид нар юм.(2оноо)
A.Кино урлагт B.Утга зохиолд C.Бүжгийн урлагт D. Хөгжмийн урлагт E. Дүрслэх урлагт

55. Манжийн үеэс одоог хүртэл уламжилж ирсэн засаг захиргааны нэгж аль нь вэ?(1оноо)
A. Нийслэл B. ДүүрэгC. СумD. Хороо E. Хошуу

56. 1992 оны Үндсэн хуулинд зааснаар Монгол улсын ерөнхийлөгч нь:(1оноо)
A. Төрийн болон гүйцэтгэх засаглалын тэргүүн
B. Төрийн тэргүүн, монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч
C. Төрийн тэргүүн бөгөөд монголын ард түмний эв нэгдлийн бэлэгдэл
D. Дээрх хариулт бүгд зөв
E. Дээрх хариулт бүгд буруу

**Хоёрдугаар хэсэг**

2.1Дараах өгөгдлүүдийг зөв тохируулна уу. (1,2,3,4,5 тус бүрт харгалзах утга a,b,c,d,e -ээс сонгоно уу.)
1. Дорнодын Тамсагбулгийн дурсгала. Хуучин чулуун зэвсгийн үе ( 5оноо)
2. Культегиний гэрэлт хөшөөb. Шинэ чулуун зэвсгийн үе
3. Ховдын Хойд Цэнхэрийн агуйc. Хүннүгийн үе
4. Ноён уулын соёлd. Түрэгийн үе
5. Дөрвөлжин булшe. Хүрэл, Төмрийн үе

2.2 Дараах өгөгдлүүдийг зөв тохируулна уу. (1,2,3,4,5 тус бүрт харгалзах утга a,b,c,d,e -ээс сонгоно уу.)
1. Хүннү a. Шэлүнь(5оноо)
2. Сяньби b. Моюунчур
3. Жужан c. Модунь
4. Түрэг d. Буман
5. Уйгар e.Таньшихуй

2.3Дараах өгөгдлүүдийг зөв тохируулна уу. (1,2,3,4,5 тус бүрт харгалзах утга a,b,c,d,e -ээс сонгоно уу.)
1. Монгол улсa.Жибзундамба хутагт ( 5оноо)
2. БНМАУb. Хотула
3. Олноо өргөгдсөн Монгол улсc. Ж.Батмөнх
4. Хамаг Монголын ханлигd. Чингис хаан
5. Их Монгол улсe. Ц.Элбэгдорж

2.4 Дараах өгөгдлүүдийг зөв тохируулна уу. (1,2,3,4,5 тус бүрт харгалзах утга a,b,c,d,e -ээс сонгоно уу.)
1. Заг Байдрагийн хүрэн бэлчирa.1640 он (5оноо)
2. Өвөр Монголын Долоннуурb. 1686 он

3. Ил Тарвагатайн Улаан бураас. 1688 он
4. Өвөр Монголын нутаг Ар элстэйd. 1691 он
5. Ардын Их хурлын чуулган Улаанбаатар e.1978 он